

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Балганы Даваа	Дугаар	L240
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Гурвантэс сум
Төрсөн газар	Гурвантэс сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зүүн уужмын хурал, Овоотын хийд, Гоёотын хийд, Байшинтын хийд	Сүм хийдийн дугаар	ӨГГТ 010, ӨГБД 012 ӨГГТ 009,ӨГГТ 015
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Зүүн уужмын хурал, Баяндалай сумын Байшинтын хийд

Гантулга: За Балган гуай та эхлээд өөрийн намтраа товч танилцуулахгүй юу, тэгээд дараа нь энэ Зүүн уужмын хурал танай эцэгтэй ямар холбоотой байсан , тэгээд хэдэн онд байгуулагдсан, хэдэн онд хаагдсан , тэгээд ойролцоох сүм хийдүүдтэйгээ ямар холбоотой байсан тэр Байшинтын хурал энэ тэр гээд тиймээ. Тэр талаар товч ярихгүй юу?

Даваа: За энэ Байшинтын хуралд бол юу нь байсан юм гэсэн. Гэсгүй нь байсан юм гэсэн.

Гантулга: Аа энэ Уужмын хурлын үү?

Даваа: Үгүй ээ, Байшинтын хурлын.

Гантулга: Аа зөв зөв.

Даваа : Тэгээд Байшинтын хурлын гэсгүй нь байж байгаад Зүүн Уужим дээр ирээд ном эмхлэдэг нөгөө унзад. Тэгээд унзадын ажил хийж байгаад, тэгээд Зүүн Уужмыг байгуулаад...Нутагтаа сүмтэй болно гээд.Тэгж л барьсан юм гэнэ лээ.Тэгээд тэр Овоотын юутай хоёр сүм нэг юугаар боссон юм гэнэ лээ, манай эцэг тэгж ярьж байсан юм.

Гантулга: Нэг юугаар?

Даваа: Нэг онд боссон юмуу даа.

Гантулга: Аан Цагаан суварга гээд байгаатай юу?

Даваа: Тийм, Цагаан суваргатай.

Гантулга: Овоотын наана байдаг уу?

Даваа: Тийм

Гантулга: Та өөрийнхөө тухай товч танилцуулахгүй юу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Даваа : Би одоо тэр Балган гэдгийн хүү нь .Тэгээд манай эцэг намайг амьдад гээд номоо цээжлүүлдэг байсан надад.Тэгээд тэр цээжлүүлсэн ном нь одоо яахав надад...

Гантулга: Бага байхдаа танайх бол тэр хавиар нутаглаж байсан айл гэж байгаа ш дээ, тиймээ?

Шархүү: Тийм, манайх тэр Тусны өвөлжөөнд байдаг байсан.

Гантулга: Аав чинь бол тэр хийдийнхээ ойролцоо?

Шархүү: Тийм, хийд дээрээ. Тэр мараа, хүнхэр, шонхор гээд л цаад руугаа байдаг байсан гэсэн.

Гантулга: Та багадаа хийдийн тэр хавиар явж байсан уу, аав дээрээ ирж очиж?

Шархүү. Аа ирэх нь ч ирж байсан л даа.

Гантулга: Тэр хурал номын талаар тэр үед үзэж харж байсан дурсамж?Ямар байшин, суварга, дуган?

Шархүү: Тэр ч яахав , нэг жижигхэн л юу байдаг байсан .Тэгээд тойроод суучихдаг...

Гантулга: Хэдэн дугантай байсан?

Шархүү: Ганц л гэдэг гэсэн.

Гантулга: Ганц дуган нь тэр нэг ийм сайр байдаг, сайрныхаа үрд зүүн дээр байсан уу? Овгор дээр байсан уу?

Шархүү: Тэр овгор дээр байсан.

Гантулга: Зүүн үрд овгор дээр үү?

Шархүү: Тийм , тэгээд тэр нэг юу байдаг байсан.

Гантулга: Аа мөн, жас нь хаанаа байсан юм ?

Шархүү: Ерөнхийдөө бол тэр хажуу талдаа сүмтэй. Тэр дотор нь бол тэр хоол ундаа хийдэг.

Гантулга: Зүүн талд нь уу, баруун талд уу. Зүүн талд нь нэг бүүр байна лээ?

Шархүү: Тэр овгорын чинь зүүн талд.

Гантулга: Аа мөн өмн. Суварга энэ тэр юм бол байгаагүй юу?

Шархүү: Одоо тиймэрхүү юмнууд байсан л байх даа.

Гантулга: Бас нэг ийм дугуй шавар байшингийн ором байна лээ? Шавраар хийчихсэн, одоо яг дуганы хэрэм шиг дугуй?

Шархүү: Тэр чинь нэг мохой складархуу юм барьчихсан байсан юм..Тэгээд л тэрнээсээ яагаад л , юм мумаа аваад л...

Гантулга: Бас нэг тасалгаатай юм шиг оромнууд байна лээ, зүүн талаараа?

Шархүү: Тэр нь багийн төв байсан юм .

Гантулга: Аа мөн .

Шархүү: Багийн төвийн нэг хэдэн байшин байсан юм.

Гантулга: Сүүлд нь баг байсан юм уу?

Шархүү: Тийм, баг байсан юм., баг байсан юм.

Гантулга: Хэддүгээр баг гэж?

Шархүү: Дөрөвдүгээр баг гэж.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Баг бас тэрүүгээр байсан?

Шархүү: Тийм, дөрөвдүгээр баг гэж...

Гантулга: Ер нь Зүүн Уужмын хурал гэхээсээ гадна Төвд нэрээрээ байх уу?Энэ хурлын нэр?

Шархүү: Байхгүй.

Гантулга: Энэ байгуулагдсан оныг нь та хэлвэл, тэдэн он ч гэдэг юмуу, тэр жил ч гэдэг юм уу?

Шархүү: Байгуулагдсан он гэвэл одоо , юу гэдэг билээ энэ чинь...Хорин гурван онд билүү дээ.

Гантулга: Аан мянга есөн зуун...?

Шархүү: Тийм.

Гантулга: Таны аав чинь одоо зуу хүрээд өнгөрсөн хүн байна ,тиймээ?

Шархүү: Тэгсэн.

Гантулга: Хэдэн онд билээ, наян...?

Шархүү: Наян дөрвөн онд өөд болсон.

Гантулга: Энэ хурал байгуулагдахдаа хэдтэй байсан гэж ярьж байсан, ер нь тэгж ярьж байсан уу?

Шархүү:Тэр талаар бол ёстой яриагүй.

Гантулга: Энэ ойролцоо сүм хийдүүдийн талаар ярих уу, та тэр суваргын , овоотын хурал дээр яаж байсан , Байшинтын хийд дээр гээд тэрний талаар товч?

Шархүү: Тэгээд юу л даа, Байшинтын хийдийн гэсгүй ч байсан гэж ярьдаг байсан. Тэр бол олон ламтай байсан байх аа, очоогүй.

Гантулга: Их том хийд байсан?

Шархүү: Тийм , том хийд байсан.Тэр Овоотын юу дотроо...

Гантулга: Нэлээн том байсан?

Шархүү: Тийм .Суварга бол нэг арван хэдэн хүнтэй.

Гантулга: Хүний тоо нь арван хэд?

Шархүү: Арван хэдэн бандитай л байсан.

Гантулга: Энэ хурлууд хоорондоо тэр том хийдээс ирж очиж байсан уу, харилцаа холбоо?

Шархүү: Өө байлгүй яахав. Дандаа хаяа байсан, юуны хаяа...Бүх хийдүүд чинь Байшинтын хаяа байсан.

Гантулга: Одоо жич тоолвол, нэрлэвэл? Суварганы хийд...

Шархүү: Суварганыхаас өмнө энэ Гоёотод нэг байна.

Гантулга: За Гоёотод нэг байна, энэ бас тэр Байшинтын л хаяа хийд?

Шархүү: Мөн л Байшинтын хаяа хийд.

Гантулга: Өөр ?

Шархүү: Өөр , тэгээд л болоо доо. Тэр Суварга байсан юм , Уужмынх байсан юм.

Гантулга: Овоот бол хамаагүй юу?

Шархүү: Овоот чинь бовол ер нь...

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Бие даасан?

Шархүү: Мөн л Байшинтын хаяа.Гэхдээ Овоотоос зарим юмнуудаа яадаг, урдаас зөөдөг байсан .

Гантулга: Цаас зураг нь уу?

Шархүү: Тийм, тэр хурал номынхоо юмнуудыг л зөөдөг байсан

Гантулга: Овоотынхоо хурлаас уу?

Шархүү: Тийм

Гантулга: Төвдийн одоо том том хийдүүдтэй холбоотой энэ тэр юмыг нь бол та мэдэхгүй юу?

Шархүү: Аа тэрийг бол мэдэхгүй.

Гантулга: Энэ бол дан шарын шашны сүм хийдүүд үү?

Шархүү: Дан шарын шашны.Нэг л янзын.

Гантулга: Тэр Зүүн Уужмын хурал дээр хичнээн дуган суварга байсан гэнэ ээ?Нэг л цогчин дуган байсан уу?

Шархүү: Тэгсэн.

Гантулга: Өөр?

Шархүү: Тэгээд л уул нь бол хоёр бодь гөрөөстэй, хэдэн суваргатай.Олон л юутай байдаг гэсэн.

Гантулга: Суварга байсан уу, тэр хойд талын царны ар талаар, хоёр хажуу талаар бас дөрвөлжин дөрвөлжин суварга байсан гэмээр?

Шархүү: Тийм. Суварга байсан.

Гантулга: Тийм суварга байсан болов уу гэмээр тийм ормууд байсан юм.Тэдэн суварга, тийм тийм юм байсан гээд сайн мэдэхгүй юу?

Шархүү: Сайн мэдэхгүй.

Гантулга: Өдөр тутмын хурал нь ямар хурал байсан юм , ер нь өдөр тутмын хурал байсан уу, цагийн одоо шинийн найман...?

Шархүү: Өдөр тутам л байсан, тэр чинь ер нь.

Гантулга: Тиймүү?

Шархүү: Яг л тасралтгүй л байсан.

Гантулга: Дүйчэн өдрүүд байна даа.Шинийн найман энэ тэр гээд.Тэрүүгээр ямар хурал хурдаг байсан?

Шархүү: Ёстой тэрийг мэдэхгүй юм. Бодвол яадаг л байсан байх л даа.

Гантулга: Жижигхэн хурал болохоор цам гардаг байсан болов уу?

Шархүү: Үгүй

Гантулга: Сор залах талаар ?

Шархүү: Овоот болвол цам тавьдаг байсан .

Гантулга: Энэ Уужим бол тийм юм байхгүй?

Шархүү: Энүүгээр бол байхгүй.

Гантулга: Хичнээн лам нартай байсан гэнэ ээ?ь

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Шархүү: Арван найман ламтай байсан юм , Уужим нь.

Гантулга: Лам нарыг нь одоо тийм цорж ийм гэсгүй гэж нэрлэвэл?Цол мяндагаар нь ?

Шархүү: Үгүй, тийм юм мэдэхгүй.

Гантулга: Тэрийг нь хэлж мэдэхгүй юу?

Шархүү: Хэлж мэдэхгүй.

Гантулга: Дотроо зүгээр л цогчин дуган...Дацан суваргууд бол байгаагүй юу?

Шархүү: Байсан.

Гантулга: Байсан уу, дотроо нийтдээ нэг дороо л уу?

Шархүү: Тийм.

Гантулга: Энэ ер нь хэдэн дацан байсан бол, та мэдэж байна уу?

Шархүү: Мэдэхгүй. Бага байхад ажигладдаггүй байсан л даа. Тойроод л гардаг байсан.

Гантулга: Одоо ямар хугацаатай номоо үздэг, тэр жилдээ энэ тэр гэж хугацаа байхгүй юу?

Шархүү: Мэдэхгүй.

Гантулга: Том том эрдэмтэй лам нар, одоо танай ааваас гадна. Танай аав чинь одоо Балган унзад ч гэдэг юм уу, тийм цол хэргэм байсан уу?

Шархүү: Тийм , унзад л гэдэг байсан даа.

Гантулга: Гавж , юмуу гэвш ч гэдэг эсвэл цорж гэж тийм цол хэргэм байсан уу? Дууддаг?

Шархүү: Байдаг л байсан байлгүй дээ, одоо улсууд бол дуудахдаа Балган гэлэн л гэдэг байсан.

Гантулга: Аа гэлэн цолтой байсан уу?

Шархүү: Гэлэн байсан.

Гантулга: Том лам нар нэртэй хутагт хувилгаан нар ирж байсан талаар нь мэдэхгүй юу та?

Шархүү: Мэдэхгүй, тэрнийг нь .

Гантулга: Лам нар нь ер нь тэр цогчин дуганыхаа хаагуур нь байсан , ер нь хойгуур нь л байсан уу?

Шархүү: Байр...

Гантулга: Байр орон сууцанд байсан уу?

Шархүү: Байруд нь дандаа урдуураа. Зүүн салаагаад...

Гантулга: Зүүн салаагаад?

Шархүү: Тийм, тэрүүгээр зарим нь байсан.Энтээ талаар нэг хөтөл шиг юм байна аа...

Гантулга: Тийм байна?

Шархүү: Тэнд байсан юм. Тэрүүгээр л гэрүүд...Гэрүүд л байдаг байсан юм.

Гантулга: Аа тийм байна, чулуун довжоотой гэрүүд?

Шархүү: Тийм гэрүүд байсан.

Гантулга: Жас ямар жастай байсан бэ? Тэрийг нь мэдэх үү?

Шархүү: Мэдэхгүй

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Мөргөлчид их очдог байсан газар уу, ер нь ойр хавийнх нь ?

Шархүү: Аа тэр орчмынх нь бол ер нь сайн цугладаг байсан.

Гантулга: Очоод одоо ямар зан үйл хийх үү, эргэл мөргөл хийх үү, ном мом залах уу, ном хурах үү?

Шархүү: Өө ном зална...янз янзын л юм хийнэ.

Гантулга: Одоо ингээд танай аавын талаар тийм хүнийг ингээд эдгээчихжээ, одоо ард түмний дунд домог болсон олон түмний дунд яригддаг ийм домог түүх байна үү?Одоо танай аавын тухай ч юм уу, тэрэн дээр байсан өөр лам нарын тухай? Эрдэмтэй лам нарын тухай нэг домгууд байдаг ш дээ.

Шархүү: Байхгүй ээ, тийм юм ердөө.

Гантулга: Ойр хавьд нь тэр тахидаг газрууд нь ямар газар байсан юм? Уул ус?

Шархүү: Тэр Тахилга овоо гэж доорд руу бий.Тустын өвөрт.

Гантулга: Тустын өвөрт өө, тэр доорд руу гэдэг нь баруун хойшоо юу, зүүн хойшоо юу?

Шархүү: Үгүй тэр , сайр луугаа уруудаад.

Гантулга: Уруудаад үү?

Шархүү: Тийм, уруудаж байгаад нэг овоо бий. Тахилга овоо гээд...

Гантулга: Өөр нэр байхгүй юу?

Шархүү: Байхгүй, Тустыг л тахидаг байсан. Тустын уул гээд..

Гантулга: Яаж тахидаг байсан энэ тэр гэж?

Шархүү: Өө мэдэхгүй. Тэр тахилга яаж байхад би чинь очихгүй л дээ, хүүхэд чинь .

Гантулга: Социализмын үед ер нь тахиж байсан үү?

Шархүү: Аан?

Гантулга: Социализмын үед ер нь тахиж байсан үү?

Шархүү: Үгүй, ёстой тахиагүй.

Гантулга: Сүм хийд нь одоо нураагдсан, хаагдсан тухай, та одоо яг мэддэг ээ, хэдийд хаагдсан ном бурхан шашныг нь ингэсэн тэгсэн, тэгээд л тимй хүмүүс очиж тэгж тэр үед ингэж сүйтгэж байсан талаар? Лам нарыг нь хааш нь баривчилсан, хорьсон уу, хороосон уу?

Шархүү: Тэгээд л лам нар ч бол ер нь тараад алга болсон доо. Манай эцгийг нэг яагаад , тэгээд сүүлд яагаад ...дахиж баригдаад.Тэгээд яачихсан юм. Наад лам нар нь бол тэгээд тэр үедээ л зүйл дууссан байх аа даа.

Гантулга: Одоо танай аав бол арван жил хоригдсон гэж түрүүн та хэлж байсан ш дээ?

Шархүү: Тийм.

Гантулга: Тэгж ямар байцаалт авч байсан, тэгж шоронд яаж байсан гээд тэр талаар нь , хаашаа авч явсан юм бэ?

Шархүү: Ер нь аймагт л байсан. Тэнд их зовоодог л байсан... Тэгээд арван жил ч болоогүй, арван жилээр таслагдаад дөрвөн жил болоод л гараад ирсэн.

Гантулга: Тэгээд зуу хүртлээ наslaад л ?

Шархүү: Тийм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ шашны зан үйлээ хийж байсан уу, үлдсэн улсуудтайгаа холбоотой байсан уу, ер нь ?

Шархүү: Үгүй яахав дээ, бас гуйсан улсуудад нь ном зом уншиж яадаг л байсан. Тэгээд нууцаар л , хориод байсан л даа.

Гантулга: Тэр гол шүтээн нандин судар энэ тэр, нандин бурхан шүтээн судар мудар нь тийм сахиустай шүтээнтэй ядамтай байсан гэж танд хэлж байгаагүй юу?

Шархүү: Үгүй.

Гантулга: Өөрт нь бол тийм хадгалж ирсэн юм бол байгаагүй?

Шархүү: Байгаагүй байлгүй дээ. Ер нь бүх юм нь хураагдчихсан юм чинь.

Гантулга: Өө за?

Шархүү: Хураагдаад, тэр хурлын юмнууд ном судар бүгд хураагсан.

Гантулга: Агуйд нэг нуусан энэ тэр гээд түрүүн нэг хэлж байсан?

Шархүү: Өө тэр агуйд байсан юмнуудыг чинь бас бүгдийг нь дуусгаад хаячихсан юм билээ.

Гантулга: Хаана, аль уулын агуйд?

Шархүү : Тэр Ямаан усны агуйд бас хэдэн ном судар байсан. Тэрийг нь алга болгочихсон...

Гантулга: Тэр чинь Тустын уулын хаахна, Ямаан усны агуй чинь?

Шархүү: Тустын хамар өвөрт бий.

Гантулга: Тэрийг нь та яг нүдээрээ үзэж байсан уу, сүүлд том болсон хойноо?

Шархүү: Өө тэр бүгдийг нь дуусгачихсан хойно нь үзсэн.

Гантулга: Юу ч үгүй сүйтгэчихсэн байна уу?

Шархүү: Юу ч үгүй.

Гантулга: Одоо энэ хурлыг бол сэргээсэн барьсан юм бол байхгүй юм байна , тиймээ?

Шархүү: Байхгүй, ер нь .

Гантулга: Энэ сумын төв дээр ер нь энэ хурлуудаа нааш нь төвлөрүүлээд сэргээж барих ажил хийгдэх үү , одоо?

Шархүү: Мэдэхгүй, нэг сүм барих юм яригдаад л байсан. Тэгээд баригдаж шалихгүй өнгөрөөд л байх шиг л байна аа.

Гантулга: Ер нь танай сумын нутагт энэ сүм хийдүүдийнхээ юунд ч юмуу, том лам нарынхаа дурсгалд зориулсан суварга байна уу, одоо шинээр босгосон?

Шархүү: Байхгүй.

Гантулга: Ерөөсөө нэг ч суварга байхгүй юу?

Шархүү: Нэг ч байхгүй.

Гантулга: Та энэ туурийн талаар нэг зураглал өгч чадах уу, одоо энд нь цогчин байсан гээд?

Шархүү: Тэгж зураглал өгч чадахгүй. Бараг мэдэхгүй.

Гантулга: За баярлалаа.

Шархүү: За баярлалаа. За баяртай.